

ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛ



МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2026 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛД ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛӨӨС ӨГӨХ ДҮГНЭЛТ

УЛААНБААТАР ХОТ

2026 оны 08 дугаар сарын 19-ний өдөр

МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2026 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛД ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛӨӨС ӨГӨХ ДҮГНЭЛТ

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3 дахь хэсэгт “... хагас жилийн нэгдсэн төсвийн гүйцэтгэлд ажлын 14 өдрийн дотор Төсвийн тогтвортой байдлын зөвлөл дүн шинжилгээ хийж, дүгнэлт, саналын хамт Улсын Их Хурлын гишүүд, холбогдох Байнгын хороо, Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ ...” гэж заасны дагуу Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны эхний хагас жилийн гүйцэтгэлд Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс дараах дүгнэлтийг гаргаж байна.

НЭГ. МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2026 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Төсвийн тогтвортой байдлын зөвлөл (ТТБЗ) нь Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны эхний хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг дараах 5 чиглэлээр шинжилж, дүгнэлт, санал, зөвлөмж гаргалаа. Үүнд:

1. Төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт, тасалдлын шалтгаан;
2. Төсвийн зарлагын гүйцэтгэл ба зарлагын бүтэц;
3. Төсвийн алдагдал, түүнийг санхүүжүүлж буй эх үүсвэр;
4. Улсын болон орон нутгийн төсөв, Нийгмийн даатгалын болон Эрүүл мэндийн даатгалын сангийн гүйцэтгэл;
5. Монгол Улсын 2026 оны нэгдсэн төсөвт учирч болзошгүй эрсдэл.

1.1. Төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт, тасалдлын шалтгаан

Нэгдсэн төсвийн нийт орлого ба тусламж 2026 оны эхний хагас жилд 16,848.7 тэрбум төгрөгт хүрч 95.1 хувийн биелэлттэй гарсан бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2,815.9 тэрбум төгрөгөөр буюу 20.1 хувиар өссөн байна. Харин төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг 16,073.2 тэрбум төгрөг байхаар төлөвлөсөн хэдий ч энэ оны эхний 6 сарын байдлаар 14,629.7 тэрбум төгрөг буюу 91.0 хувийн гүйцэтгэлтэй гарч 1,443.5 тэрбум төгрөгөөр тасарсан байна.

Хүснэгт 1. Нэгдсэн төсвийн 2026 оны эхний хагас жилийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Нийт орлого ба тусламжийн дүн	17,723.5	16,848.7	-874.8	95.1%
Тэнцвэржүүлсэн нийт орлого	16,073.2	14,629.7	-1,443.5	91.0%
Татварын орлого	14,862.3	13,427.5	-1,434.8	90.3%
Татварын бус орлого	1,210.9	1,202.2	-8.7	99.3%
ААНОАТ	3,362.1	2,496.4	-865.7	74.3%
НӨАТ	3,430.0	3,219.8	-210.2	93.9%
Онцгой албан татвар	625.9	438.3	-187.6	70.0%
Гадаад үйл ажиллагааны орлого	1,099.0	962.7	-136.3	87.6%

Эх сурвалж: Сангийн яам. МУНТ-ийн 2026 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн мэдээ.

Төсвийн орлого ийнхүү тасарсан нь энэхүү тасалдлын 99.4 хувийг эзэлж буй татварын орлогын дутуу гүйцэтгэлтэй холбоотой. Татварын орлого төлөвлөгөөнөөс 1,434.8 тэрбум төгрөгөөр дутуу төвлөрсөн бол татварын бус орлогын тасалдал 8.7 тэрбум төгрөг байна.

Татварын орлогын тасалдал нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар (ААНОАТ) дутуу төвлөрснөөс голлон шалтгаалсан байна. Татварын орлогын дотор ААНОАТ-ын гүйцэтгэл 74.3 хувьтай гарч, 865.7 тэрбум төгрөгөөр дутуу төвлөрсөн (татварын орлогын

нийт тасалдлын 60.3 хувийг эзэлж байгаа) нь татварын орлого төлөвлөлтийн үндэслэл, тооцоололтой холбоотой том дохио юм. Өөрөөр хэлбэл, энэ нь уг татварын орлогын төлөвлөлт, төсөөлөл бодитой байсан эсэхийг болон тасалдлын үндсэн шалтгааныг нарийвчлан тодорхойлох шаардлагатайг илтгэнэ. Мөн олон улсад ААНОАТ нь бизнесийн цикл буюу эдийн засгийн мөчлөг даган өөрчлөгддөг талаар баримт бий¹.

Иймээс УИХ-аас Засгийн газарт ААНОАТ-ын жилийн төлөвлөгөөг ямар ашигт ажиллагааны төсөөлөлд үндэслэсэн боловсруулсан, уул уурхайн болон уул уурхайн бус салбарын ашгийн төсөөлөл ямар байсан, татварын орлогын төлөвлөгөөнд нэг удаагийн орлого хэт өндөр туссан эсэх, татварын өр, авлага, буцаан олголтын өөрчлөлт ямар нөлөө үзүүлсэн, төсвийн орлогын эхний хагас жилийн тасалдал бүтэн жилд нөхөгдөх боломжтой эсэх талаар асуулт тавих нь зүйтэй гэж үзэж байна.

Нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ)-ын гүйцэтгэл 3,219.8 тэрбум төгрөг буюу 93.9 хувьтай байгаа нь ААНОАТ-тай харьцуулахад харьцангуй сайн үзүүлэлт юм. НӨАТ-ын орлогыг төрлөөр нь авч үзвэл, дотоодын барааны НӨАТ 95.5 хувь, импортын барааны НӨАТ 93.7 хувь, НӨАТ-ын буцаан олголт 99.3 хувийн биелэлттэй гарчээ. Импортын барааны НӨАТ-ын гүйцэтгэл 93.7 хувь байгааг импортын хэмжээ, бүтэц, валютын ханш, дотоодын хэрэглээний төлөвтэй уялдуулан нарийвчлан шинжлэх шаардлагатай.

Онцгой албан татвараар төсөвт 438.3 тэрбум төгрөг төвлөрч ердөө 70.0 хувийн гүйцэтгэлтэй байна. Ялангуяа автомашины онцгой татвар 61.9 хувь, дотоодын архи, дарсны татвар 63.8 хувь, дотоодын пивоны татвар 69.2 хувь, автобензин, дизелийн түлшний онцгой татвар 52.0 хувийн биелэлттэй байна. Гаалийн ерөнхий газрын статистик мэдээллээс үзвэл оны эхний 6 сард импортоор авсан суудлын автомашины тоо 19.8 мянгаар, үнийн дүн нь 160.0 сая ам.доллараар, мөн ачааны автомашины импортын тоо хэмжээ 2.7 мянгаар, үнийн дүн нь 68.3 сая ам.доллараар тус тус буурчээ. Ийнхүү гаалийн албан татвар, онцгой албан татвар харьцангуй өндөр ногддог автомашины импорт буурч байгаа нь импортын барааны гааль, НӨАТ, онцгой албан татвар буурахад нөлөөлсөн байна.

Харин оны эхний 6 сард импортоор худалдан авч байгаа автобензин, дизелийн түлшний импорт нэмэгдэж байгаа боловч Засгийн газраас өнгөрсөн хугацаанд гаргасан удаа дараагийн шийдвэрийн дагуу үүнд ногдуулах онцгой албан татвар, гаалийн татварыг бууруулсан тул төсвийн орлого бүрдүүлэлтэд төдийлөн эерэг нөлөө үзүүлээгүй байна.

Хэдийгээр Сангийн яам, үүний дотор Төсвийн бодлого төлөвлөлтийн газар жил бүрийн төсвийн орлогыг аль болохоор бодитой төлөвлөхийг хичээж ирсэн ч өөдрөг төлөвлөхөд хүргэж байгаа нөхцөл, шалтгаан оршсоор байна. Сүүлийн жилүүдэд хэт тэлсээр байгаа төсвийн зарлагыг нөхөх үүднээс төсвийн орлогыг шахаж, бодитой бус хийсвэр төлөвлөлт хийж байна.

Татварын зарим орлого маш өндөр биелэлттэй (агаарын бохирдлын төлбөр 189.2 хувь, ус бохирдуулсны төлбөр 414.1 хувь, ашигт малимал ашигласны зарим төлбөр 100 орчим хувь) ***байхад*** дээр дурдсан ***томоохон татваруудын орлого 20–30 хувиар тасарсан байна.*** Энэ нь жилийн төсвийн орлогын төлөвлөгөөний суурь тооцоо, улирлын хуваарилалт, макро таамаглалын нийцлийг дахин үнэлэх, зөвхөн жилийн дүнгээр тооцохоос гадна улирлын болон хагас жилийн төсвийн орлогын хуваарилалт нь орлогын улирлын бодит байдалтай

¹ Leal, Teresa & Pérez, Javier J. & Tujula, Mika & Vidal, Jean-Pierre, 2007. "Fiscal forecasting: lessons from the literature and challenges", Working Paper Series 843, European Central Bank.

нийцэж байгаа эсэхийг шалгах, төлөвлөгөө ба гүйцэтгэлийн зөрүүг багасгахад анхаарах шаардлагатайг харуулж байна. Иймээс 2026 оны сүүлийн хагасын орлогын төсөөллийг татварын төрөл тус бүрээр шинэчилж, ялангуяа ААНОАТ, онцгой албан татвар, импортын татварын суурийг бодит гүйцэтгэлтэй нь уялдуулан дахин тооцох хэрэгтэй.

1.2. Төсвийн зарлагын гүйцэтгэл ба зардлын бүтэц

Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн хэмжээг 2026 оны эхний хагас жилд 18,090.8 тэрбум төгрөг байхаар төлөвлөсөн бол гүйцэтгэлээр 16,773.3 тэрбум төгрөг буюу 92.7 хувийн биелэлттэй гарчээ. Төлөвлөснөөс 1,317.5 тэрбум төгрөг дутуу зарцуулсан бөгөөд үүнийг бүхэлд нь төсвийн бодит хэмнэлт гэж үзэж болохгүй. Ялангуяа хөрөнгө оруулалтын зардлыг Төрийн хэмнэлтийн тухай хуультай холбоотойгоор царцааж байгааг хэмнэлт хэмээн үзэх боломжгүй юм. Энэхүү дутуу зарцуулалт нь орлогын тасалдлыг хэсэгчлэн сааруулсан боловч төсвийн алдагдлыг төлөвлөсөн түвшинд барихад хангалтгүй байв. Гэхдээ төсвийн нийт зарлага өмнөх оны мөн үеэс 2,799.9 тэрбум төгрөгөөр буюу 20.0 хувиар өссөн байна.

Хүснэгт 2. Нэгдсэн төсвийн 2026 оны эхний хагас жилийн нийт зарлага ба цэвэр зээлийн гүйцэтгэл

Зардлын ангилал	Төлөвлөгөө тэрбум төг.	Гүйцэтгэл тэрбум төг.	Зөрүү тэрбум төг.	Биелэл- тийн хувь	Нийт дүнд эзлэх хувь
Нийт зарлага ба цэвэр зээл	18,090.8	16,773.3	-1,317.5	92.7	100.0
Урсгал зардал	15,037.4	13,898.1	-1,139.4	92.4	82.9
Бараа, ажил үйлчилгээ	6,824.9	6,087.6	-737.3	89.2	36.3
Хүү	906.3	792.4	-113.9	87.4	4.7
Татаас	641.6	554.3	-87.3	86.4	3.3
Урсгал шилжүүлэг	6,664.6	6,463.8	-200.8	97.0	38.5
Хөрөнгийн зардал	3,061.5	2,774.5	-287.0	90.6	16.5
Эргэж төлөх төлбөрийг хассан цэвэр зээл	-8.2	100.7	108.9		0.6

Эх сурвалж: Сангийн яам. МУНТ-ийн 2026 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн мэдээ.

Нэгдсэн төсвийн зарлагын бүтцийг авч үзвэл урсгал зардал 13,898.1 тэрбум төгрөг буюу нийт зарлага ба цэвэр зээлийн дүнгийн 82.9 хувь, хөрөнгийн зардал 2,774.5 тэрбум төгрөг буюу 16.5 хувь, цэвэр зээл 100.7 тэрбум төгрөг буюу 0.6 хувийг эзэлж байна. Эхний хагас жилийн гүйцэтгэлээр урсгал зардал 1,139.4 тэрбум төгрөг (7.6%), түүний дотор бараа, ажил үйлчилгээний зардал 737.3 тэрбум төгрөг, цалин хөлс 229.2 тэрбум төгрөгөөр, мөн хөрөнгийн зардал 287.0 тэрбум төгрөг (9.4%), хүүгийн зардал 113.9 тэрбум төгрөг (12.6%)-өөр дутуу санхүүжсэн дүнтэй гарчээ.

Хөрөнгийн зардлын гүйцэтгэл 90.6 хувьтай байгааг төрлөөр нь ангилж үзвэл, барилга байгууламжийн хөрөнгө оруулалт 96.5 хувьтай буюу хэвийн үргэлжилж байгаа харагдана. Тоног төхөөрөмжийн худалдан авалт 89.3 хувийн гүйцэтгэлтэй гарчээ. Гэхдээ **хөрөнгийн зардлын 2026 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал 1,020.5 тэрбум төгрөгөөр буюу 58.3 хувиар өссөн байна.** Энэ нь нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлт болох 2.8 их наяд төгрөгийн өсөлтөд хамгийн их буюу 36.4 хувийг эзэлж байгаа нь анхаарал татаж байгаа юм.


Мөн бараа, ажил үйлчилгээний зардал нийт зарлагын өсөлтийн 36.2 хувийг эзэлж байгаа бөгөөд бараа, ажил үйлчилгээний зардлын дотор цалин, нэмэгдэл урамшууллын зардал

4,286.8 тэрбум төгрөг буюу 94.9 хувь, урсгал шилжүүлэг 6,463.8 тэрбум төгрөг буюу 97.0 хувь, хүүгийн зардал 792.4 тэрбум төгрөг буюу 87.4 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

Төрийн албан хаагчдын цалин хөлсний зардлын бүтэц

Цалин хөлсний зардлын өсөлт бараа, ажил үйлчилгээний зардлын өсөлтөд өндөр хувь эзэлж байна. Нэгдсэн төсвийн 2026 оны эхний хагас жилийн нийт зарлагыг өмнөх оны мөн үетэй харьцуулж, энэхүү зардлын өсөлтөд эзлэх хувийг тооцож үзэхэд цалингийн зардал 34.8 хувьтай байна. Түүнчлэн бараа, ажил үйлчилгээний зардлын өсөлтийн 95.9 хувийг цалин хөлс болон нэмэгдэл, урамшлын зардал эзэлж байгааг дараах зургаас харж болно.

Зураг 1. Бараа, ажил үйлчилгээний зардлын өсөлтөд цалин хөлсний зардлын эзлэх хувь



Эх сурвалж: Сангийн яам. МУНТ-ийн 2026 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн мэдээ

Нийт цалин хөлсний зардал төлөвлөсөн хэмжээнд зарцуулагдаагүй боловч үндсэн цалингийн зардал төлөвлөгөөнөөс давсан байна. Монгол Улсын 2026 оны эхний хагас жилийн нэгдсэн төсвийн зарлагын гүйцэтгэлээр цалин хөлс, нэмэгдэл урамшилд 4,286.8 тэрбум төгрөг зарцуулсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 973.0 тэрбум төгрөгөөр буюу 29.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 3. Нэгдсэн төсвийн 2025, 2026 оны эхний хагас жилийн цалин хөлсний зардал

ҮЗҮҮЛЭЛТ	2025 оны эхний хагас жилийн гүйцэтгэл	2026 оны жилийн төсөв	2026 оны эхний хагас жилийн		Зөрүү 5=2-1	Зөрүү 6=4-2	Зөрүү 7=4-3
			Төлөв- лөгөө	Гүйцэт- гэл			
А	1	2	3	4	5	6	7
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,313.8	6,997.5	4,516.0	4,286.8	973.0	(2,710.7)	(229.2)
Үндсэн цалин	2,372.7	3,921.8	2,733.8	3,337.1	964.4	(584.7)	603.2
Нэмэгдэл	687.8	2,445.6	1,425.8	667.9	(19.9)	(1,777.6)	(757.9)
Унаа хоолны хөнгөлөлт	140.6	265.6	169.8	161.9	21.3	(103.7)	(7.9)
Урамшуулал	72.5	324.3	137.8	78.3	5.8	(245.9)	(59.4)
Гэрээт ажлын хөлс	40.2	40.3	48.8	41.6	1.4	1.3	(7.2)

Эх сурвалж: Сангийн яам. МУНТ-ийн 2026 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн мэдээ

Гэхдээ нийт цалин хөлсний зардал 94.9 хувийн гүйцэтгэлтэй, төлөвлөгөөнөөс 229.2 тэрбум төгрөгөөр бага гарсан нь цалингийн зардал энэ дүнгээр хэмнэгдсэн гэсэн үг биш. Учир нь үндсэн цалингийн зардал төлөвлөгөөнөөс 603.2 тэрбум төгрөгөөр буюу 22.1 хувиар давсан

байна. Харин нэмэгдлийн зардал 757.9 тэрбум төгрөгөөр буюу 53.2 хувиар дутуу санхүүжсэн учир нийт цалин хөлсний зардал төлөвлөснөөс доогуур дүнтэй гарахад нөлөөлжээ.

Хүснэгт 4. Нэгдсэн төсвийн 2026 оны эхний хагас жилийн цалин хөлсний зардлын бүтэц

Цалингийн зардлын Ангилал	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлтийн хувь	Нийт дүнд эзлэх хувь	
					Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Цалин хөлс, нэмэгдэл урамшууллын нийт зардал	4,516.0	4,286.8	-229.2	94.9	100.0	100.0
Үндсэн цалин	2,733.8	3,337.1	603.2	122.1	60.5	77.9
Нэмэгдэл	1,425.8	667.9	-757.9	46.8	31.5	15.6
Унаа, хоолны хөнгөлөлт	169.8	161.9	-7.9	95.3	3.8	3.8
Урамшуулал	137.8	78.3	-59.4	56.9	3.1	1.8
Гэрээт ажлын хөлс	48.8	41.6	-7.2	103.2	1.1	1.0

Эх сурвалж: Сангийн яам. МУНТ-ийн 2026 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн мэдээ

Үндсэн цалингийн зардал хамгийн их өсөлттэй байна. Цалингийн зардлыг бүтцээр нь задалж үзвэл, 2026 оны эхний хагас жилд 2,733.8 тэрбум төгрөгийг үндсэн цалинд, 1,425.8 тэрбум төгрөгийг цалингийн нэмэгдэлд зарцуулахаар төлөвлөсөн бол бодит гүйцэтгэлээр үндсэн цалинд 3,337.1 тэрбум төгрөг, цалингийн нэмэгдэлд 667.9 тэрбум төгрөг зарцуулжээ.

Үндсэн цалингийн зардалд өмнөх оны мөн үед 2,372.7 тэрбум төгрөг зарцуулж байсан бол тайлант хугацаанд өмнөх үеэс 964.4 тэрбум төгрөгөөр буюу 40.6 хувиар өндөр зардал гаргасан байна. Харин урамшууллын зардал төлөвлөгөөнөөс 59.4 тэрбум төгрөгөөр дутуу гүйцэтгэлтэй бөгөөд тайлант хугацаанд 78.3 тэрбум төгрөг зарцуулсан нь төлөвлөгөөний 56.9 хувь болж байгаа боловч өмнөх оны мөн үеэс 5.8 тэрбум төгрөгөөр илүү байна.

Үүнээс гадна төсөвлөсөн цалингийн зардлын бүтцэд эзлэх үндсэн цалингийн жин 60.5 хувиас эрс нэмэгдэж 77.9 хувьд хүрч, харин нэмэгдлийн эзлэх жин 15.9 хувиар буурчээ. Нэгтгэн дүгнэвэл, цалин хөлсний нийт зардал төлөвлөгөөнөөс бага гарсан боловч зардлын дотоод бүтэц төлөвлөснөөс мэдэгдэхүйц өөрчлөгдсөн байна.

Жилийн цалин хөлс, нэмэгдэл урамшууллын төсвийн 61.3 хувийг оны эхний 6 сард зарцуулсан байна. Жилийн цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардалд 6,997.5 тэрбум төгрөг батлагдсан бол эхний хагас жилийн гүйцэтгэлээр 4,286.8 тэрбум төгрөг буюу жилийн төсвийн 61.3 хувийг оны эхний 6 сард зарцуулсан гэсэн үг. Энэ нь жилийн эцсийн цалингийн зардлын дарамтыг нэмэгдүүлэх эрсдэлтэй тул III улиралд багтаан жилийн эцсийн хүлээгдэж буй гүйцэтгэлийг шинэчлэн тооцож, санхүүжилтийг нь тодорхой болгох шаардлагатай.

Үндсэн цалингийн жилийн төсвийн 85.1 хувь нь эхний хагас жилд зарцуулагджээ. Жилийн дүнгээр төлөвлөсөн үндсэн цалингийн зардал 3,921.8 тэрбум төгрөг байсан бол эхний хагас жилийн гүйцэтгэлээр 3,337.1 тэрбум төгрөг буюу жилийн төсвийн 85.1 хувийг нь зарцуулсан байна. Хэрэв энэ гүйцэтгэл жилийн хоёрдугаар хагаст ижил хурдаар үргэлжилбэл жилийн төсөвт мэдэгдэхүйц дарамт үүсгэх эрсдэлийг дагуулж байна.

Иймээс ТТБЗ-ийн зүгээс 2026 оны цалин хөлсний зардлын жилийн эцсийн шинэчилсэн төсөөллийг үндсэн цалингийн төсөвлөлт, орон тоо, цалинг нэмэхтэй холбоотой шийдвэр, нэмэгдэл, урамшуулал, албан тушаалын ангилал, ажил олгогчийн төлөх нийгмийн даатгалын шимтгэл зэргээр задлан гаргаж, төрийн албан хаагчдын цалингийн зардлын өсөлт нь дунд

хугацааны төсвийн тогтвортой байдалд үзүүлэх нөлөөг тусгайлан үнэлэх нь зүйтэй гэж үзэж байна.

Учир нь төсвийн орлогын төлөвлөгөө тасарч байгаа үед төсвийн байгууллагууд цалин хөлсний зардлаа бууруулах боломж багатай. Нэгдсэн төсвийн татварын орлого эхний хагас жилд төлөвлөгөөнөөс 1,434.8 тэрбум төгрөгөөр дутуу төвлөрсөн, гэтэл цалин хөлс, нэмэгдэл, урамшууллын зардал 4,286.8 тэрбум төгрөгт хүрсэн. Эндээс төсвийн бодлогын хувьд орлогын мөчлөгийн хэлбэлзэлд нийцүүлэн цалингийн зардалд өөрчлөлт оруулах боломжгүй тул цалин хөлсний зардлыг дунд хугацааны төсвийн хүрээтэй уялдуулан төлөвлөх шаардлагатай юм.

Цалин хөлсний зардлыг Хувь хүний орлогын албан татвар (ХХОАТ)-ын орлоготой холбож үзвэл, 2026 оны эхний хагас жилийн ХХОАТ 1,611.5 тэрбум төгрөг буюу 90.4 хувийн гүйцэтгэлтэй, харин цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулалтай холбоотой ХХОАТ 1,217.5 тэрбум төгрөг буюу 84.5 хувийн гүйцэтгэлтэй байна. Иймээс цаашид “төрийн албан хаагчдын цалингийн зардлын өсөлт, ажиллагчдын орлого, ХХОАТ-ын орлого, төсөвт үзүүлэх цалингийн зардлын дарамт” гэсэн цогц шинжилгээ хийж байхыг Засгийн газраас шаардах хэрэгтэй байна.

Нийгмийн халамжийн зардлын гүйцэтгэл

Улсын төсвийн халамжийн сангаас 2026 оны эхний хагас жилд хүүхдийн мөнгөн тэтгэмжид 773.6 тэрбум төгрөг, халамжийн тэтгэвэрт 165.5 тэрбум төгрөг, асаргааны тэтгэмжид 142.4 тэрбум төгрөг, алдарт эхийн одонтой эхчүүдийн тэтгэмжид 66.9 тэрбум төгрөг, цалинтай ээж хөтөлбөрт 46.2 тэрбум төгрөг, амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжид 47.4 тэрбум төгрөг зарцуулжээ. ТТБЗ нийгмийн халамжийн зардлыг зөвхөн зарцуулалтын дүнгээр бус, зорилтот бүлэгт хүрсэн байдал, үр дүнгийн үзүүлэлт, төсвийн зарлагын өсөлттэй уялдуулан үнэлэх шаардлагатай гэсэн байр суурьтай байна.

Урсгал зардлын голлох хувийг эзэлдэг хүү, шилжүүлэг, тэтгэвэр, тэтгэмж зэрэг нь богино хугацаанд бууруулахад хүндрэлтэй зардлууд юм. Иймээс орлогын тасалдал үүсэх үед төсвийн алдагдлыг зарлага танах замаар богино хугацаанд тохируулах боломж хязгаарлагдмал байна. Энэ нь төсвийн бодлогын хувьд дунд хугацаанд зарлагын бүтцийн шинэчлэл хийх шаардлагатайг илтгэнэ.

1.3. Төсвийн алдагдал, түүнийг санхүүжүүлж буй эх үүсвэр

Алдагдал өсч төлөвлөсөн дүнгээс давсан байна. Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 2026 оны эхний хагас жилд 2,143.6 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан нь төлөвлөсөн алдагдлаас 126.0 тэрбум төгрөгөөр өндөр байна. Төсвийн алдагдал өмнөх оны мөн үеэс 2.8 дахин буюу -758.0 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны эхний хагас жилийн гүйцэтгэл, тэрбум төгрөг

Үзүүлэлт	2025 оны эхний хагас жилийн гүйцэтгэл	2026 он			Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулсан зөрүү	2026 оны төлөвлөгөө, гүйцэтгэлийн зөрүү
		Жилийн төсөв	Эхний хагас жилийн төлөвлөгөө	Эхний хагас жилийн гүйцэтгэл		
Нийт тэнцвэржүүлсэн орлого	13,215.5	31,933.1	16,073.2	14,629.7	1,414.2	-1,443.5

ба тусламжийн дүн						
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	13,973.4	32,983.1	18,090.8	16,773.3	2,799.9	-1,317.5
Тэнцвэржүүлсэн нийт тэнцэл	-758.0	-1,050.0	-2,017.6	-2,143.6	-1,385.7	-126.0

Эх сурвалж: Сангийн яам. МУНТ-ийн 2026 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн мэдээ

Алдагдлыг санхүүжүүлж буй эх үүсвэрийн бүтцийг анхаарах шаардлагатай. Нэгдсэн төсвийн 2026 оны эхний хагас жилийн алдагдлыг санхүүжүүлсэн эх үүсвэрийн хувьд гадаад төслийн зээлийн үндсэн төлбөрт 427.2 тэрбум төгрөг, гадаад бондын үндсэн төлбөрт 1,768.7 тэрбум төгрөг, дотоод бондын үндсэн төлбөрт 24.0 тэрбум төгрөг төлсөн бол 947.4 тэрбум төгрөгийн гадаад төслийн зээл шинээр авч, 1,885.5 тэрбум төгрөгийн гадаад бонд, мөн 686.2 тэрбум төгрөгийн дотоод бонд шинээр гаргаж алдагдлыг санхүүжүүлжээ. Тиймээс төсвийн алдагдлын шинжилгээг хийхдээ алдагдал хэд байна вэ? гэдгээр хязгаарлах бус, харин “Алдагдлыг ямар эх үүсвэрээр, ямар хугацаатай, ямар өртгөөр, ямар өрийн динамиктайгаар санхүүжүүлж байна вэ?” гэдэг рүү шилжих хэрэгтэй юм.

Иймээс ТТБЗ 2026 оны сүүлийн хагас жилд нэгдсэн төсвийн орлогын бодит боломжийг шинэчлэн үнэлэх, зарлагын эрэмбэ тогтоох, төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн бүтцийг өрийн тогтвортой байдалтай уялдуулах, мөн зарлагын гүйцэтгэлийг үр дүнтэй нь холбоход чиглүүлэх нь зүйтэй гэсэн байр суурьтай байна.

1.4. Улсын болон орон нутгийн төсөв, Нийгмийн даатгалын болон Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн гүйцэтгэл

Улсын төсвийн тэнцэл 2,794.6 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан нь төлөвлөсөн хэмжээнээс 297.7 тэрбум төгрөгөөр илүү байна.

Хүснэгт 6. Улсын болон орон нутгийн төсөв, Нийгмийн даатгалын болон Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны эхний хагас жилийн төсвийн орлого, зарлага, тэнцэл

Төсвийн бүрэлдэхүүн	Орлого, тэрбум төг.	Зарлага, тэрбум төг.	Тэнцэл, тэрбум төг.	Үнэлгээ
Улсын төсөв	8,524.3	11,318.9	-2,794.6	Нэгдсэн төсвийн алдагдалд голлох нөлөө үзүүлсэн
Орон нутгийн төсөв	3,817.3	3,709.7	107.6	Орлогын төлөвлөгөөний тасалдал өндөр
Нийгмийн даатгалын сан	3,814.6	3,335.7	478.9	Эерэг тэнцэлтэй
Эрүүл мэндийн даатгалын сан	1,282.2	1,217.6	64.6	Эерэг тэнцэлтэй

Эх сурвалж: Сангийн яам. МУНТ-ийн 2026 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн мэдээ

Орон нутгийн төсвийн орлого 3,817.3 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөгөөнөөс 691.5 тэрбум төгрөгөөр дутсан нь нэгдсэн төсвийн орлогын эрсдэлийг нэмэгдүүлэх нөлөөтэй байна. Орон нутгийн төсвийн орлого 84.7 хувь (15.3 хувиар дутуу)-тай бүрдсэн нь ХХОАТ 171.4 тэрбум төгрөг, ААНОАТ 480.6 тэрбум төгрөг, татварын бус орлого 94.4 тэрбум төгрөгөөр тус тус дутуу төвлөрсөнтэй холбоотой байна.

Харин орон нутгийн төсвийн зарлага 3,709.7 тэрбум төгрөг буюу 82.4 хувийн гүйцэтгэлтэй гарсан бөгөөд эндээс орон нутгийн төсвийн орлогын тасалдалтай уялдан зарлагыг мөн тодорхой хэмжээнд барьсныг харж болно. Гэхдээ орон нутгийн төсвийн орлого төлөвлөснөөс 691.5 тэрбум төгрөгөөр дутуу төвлөрсөн нь бага тоо биш. Энэ нь нэгдсэн

төсвийн орлого бүрдүүлэлтийн асуудлыг зөвхөн улсын төсвийн хэмжээнд авч үзэх боломжгүйг харуулна.

Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөлтийг тухайн орон нутгийн бодит татварын бааз суурь, эдийн засгийн бүтэц, өөрийн орлогын чадавхтай илүү нягт уялдуулах шаардлагатай. Мөн аймаг хоорондын төсвийн орлогын гүйцэтгэлийн зөрүү өндөр байгаа тул орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт муу байгаа шалтгааныг аймаг тус бүрээр задлан шинжилж, аймаг бүрийн орлогын баазад суурилсан төлөвлөлт хийх, өөрийн орлогын ба шилжүүлгийн хамаарлыг үнэлэх шаардлагатай гэж ТТБЗ үзэж байна.

Нийгмийн даатгалын сан 2026 оны эхний хагас жилд 478.9 тэрбум төгрөгийн эерэг тэнцэлтэй гарсан байна (орлого 3,814.6 тэрбум төгрөг буюу 102.2 хувь, зарлага 3,335.7 тэрбум төгрөг буюу 100.2 хувийн гүйцэтгэлтэй). Гэхдээ энэ үзүүлэлтэд үндэслэн шууд “сангийн санхүүгийн байдал сайн” гэж дүгнэх боломжгүй юм. Учир нь хагас жилийн эерэг тэнцэл нь тэтгэвэр, тэтгэмжийн жилийн эцсийн зарлага, шимтгэлийн орлогын динамикийг бүрэн харуулахгүй. Нийгмийн даатгалын сангийн богино хугацааны эерэг тэнцлийг урт хугацааны сангийн тогтвортой байдалтай адилтгах боломжгүй тул цаашид шимтгэлийн орлогын гүйцэтгэл болон тэтгэврийн зардлын өсөлтийг тусад нь үнэлэх шаардлагатай.

Эрүүл мэндийн даатгалын сан мөн ашигтай гарсан байна. ЭМД-ын сангийн орлого 1,282.2 тэрбум төгрөг буюу 98.2 хувь, зарлага 1,217.6 тэрбум төгрөг буюу 98.5 хувийн гүйцэтгэлтэй, тэнцэл нь 64.6 тэрбум төгрөг байна. Энэ нь гүйцэтгэлийн өндөр хувьтай, харьцангуй тогтвортой харагдаж байгаа боловч жилийн эцэст эрүүл мэндийн тусламж үйлчилгээний төлбөр, эмчилгээний зардал нэмэгдэх эсэхийг хянаж, нягтлах нь зүйтэй.

1.5. Монгол Улсын 2026 оны нэгдсэн төсөвт учирч болзошгүй эрсдэл

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны эхний хагас жилийн гүйцэтгэлээс үзэхэд төсөв, төсвийн тогтвортой байдалд учирч болох гол эрсдэл нь зарлагын төлөвлөгөөний хэтрэлтээс илүү татварын орлогын төлөвлөгөөний биелэлт сул байгаа явдал юм. Ийм нөхцөлд төсвийн зарлагын өндөр гүйцэтгэл хадгалагдаж, үүний улмаас алдагдлын хэмжээ төлөвлөсөн түвшнээс нэмэгдэж, алдагдлыг өрийн эх үүсвэрээр санхүүжүүлэх хэрэгцээ үүсэхээр байна.

Хүснэгт 7. Төсвийн эрсдэлийн матриц

Эрсдэл	Магадлал	Нөлөөлөл	Үндэслэл	Хэрэгжүүлэх арга хэмжээ
Татварын орлогын тасалдал	Өндөр	Өндөр	ААНОАТ 74.3 хувь, онцгой албан татвар 70.0 хувийн гүйцэтгэлтэй	Сүүлийн хагас жилийн орлогын шинэчилсэн төсөөлөл болон сар бүрийн орлогын стресс-тест хийх
Орон нутгийн орлогын тасалдал	Өндөр	Дунд-өндөр	691.5 тэрбум төгрөгийн тасалдалтай	Аймаг бүрээр шалтгаан, өөрийн орлогын баазыг дахин үнэлэх
Зарлагын хэрэгжилтийн хоцрогдол	Дунд	Өндөр	Зарлагын гүйцэтгэл 92.7 хувь, санхүүжээгүй үлдэгдэл их	Хөрөнгө оруулалтыг биет гүйцэтгэлтэй нь тулгах
Өрийн үйлчилгээний дарамт	Дунд	Өндөр	Хүүгийн зардал 792.4 тэрбум төгрөг	Шинэ өрийн өртөг, валютын бүтэц, хугацааг алдагдалтай уялдуулах
Алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн эрсдэл	Дунд-өндөр	Өндөр	Төсвийн алдагдал төлөвлөгөөнөөс өндөр гарсан	Санхүүжилтийн эх үүсвэрийн нэгдсэн cash-flow төлөвлөгөө боловсруулах

Халамж, урсгал шилжүүлгийн зардлын дарамт	Дунд	Өндөр	Урсгал шилжүүлэг 6,463.8 тэрбум төгрөг	Үр дүн, зорилтот байдлыг үнэлж, эрэмбэ тогтоох
---	------	-------	--	--

Улмаар 2025 оны төсөв дээр үүссэнтэй адилаар төсвийн зарим тусгай шаардлага 2026 онд ч зөрчигдөх, оны эцсээр төсвийн орлогын дутагдлын улмаас 1,247.9 тэрбум төгрөгийг компаниудаас 2026 оны татварын орлогын урьдчилгаа болгон авч ашигласан нөхцөл байдал давтагдах эрсдэл нүүрлээд байна.

ХОЁР. ДҮГНЭЛТ

1. Монгол Улсын 2026 оны эхний хагас жилийн төсвийн гүйцэтгэл нь *хурдацтай тэлэлт болон бүтцийн тэнцвэргүй байдал* гэсэн *хоёр эсрэг дүр* төрхтэй байна. Нийт орлого өмнөх оны мөн үеэс өссөн хэдий ч төрийн албан хаагчдын (ялангуяа багш, эмч нарын) цалин, тэтгэвэр тэтгэмжийг шат дараалан нэмэгдүүлсэн нь урсгал зардлыг ихээхэн хэмжээгээр өсгөжээ. Үүний улмаас төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэлд 2.1 их наяд төгрөгийн алдагдалтай гарахад нөлөөлсөн гэж үзэж байна.
2. Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 2026 оны эхний хагас жилд төлөвлөгөөнөөс 1,443.5 тэрбум төгрөгөөр, татварын орлого 1,434.8 тэрбум төгрөгөөр дутуу төвлөрсөн нь төсвийн тэнцлийг муутгах гол шалтгаан болжээ.
3. Орлогын тасалдлын эрсдэл нь ААНОАТ болон онцгой албан татварын төлөвлөгөөний биелэлт сул байсантай холбоотой байна. ААНОАТ-ын тасалдал дангаараа 865.7 тэрбум төгрөг байгаа нь татварын орлогын төлөвлөлтийн чанар, төсөөллийг дахин шалгах шаардлагатайг харуулж байна.
4. Төсвийн орлогыг бодит байдлаас өндөр төлөвлөснөөр төсвийн зарлагыг санхжүүжүүлж чадахгүйд хүрэх, улмаар төсвийн алдагдал ихээр нэмэгдэж, улсын төсвийн тодотгол хийх таагүй нөхцөл байдалд хүргэхээр байна. Иймээс УИХ, Төсвийн Байнгын хорооны зүгээс төсвийн орлого төлөвлөлтийг ирэх жилийн макро эдийн засгийн бодит орчин, бүс нутгийн геополитикийн нөхцөл байдал, учирч болзошгүй эрсдэлд тулгуурлан илүү бодитой төлөвлөхийг Засгийн газраас шаардах хэрэгтэй.
5. Төсвийн зарлагын өсөлтөд тааруулж төсвийн орлогыг зохиомлоор нэмэгдүүлж, алдаатай төлөвлөж байгаа өнөөгийн алдааг засах, тоо мөргүүлэх бус, төсвийн бодлогыг илүү тэргүүн ээлжинд анхаарч төлөвлөлт хийж байх шаардлагатай.
6. Нэгдсэн төсвийн зарлага төлөвлөгөөнөөс доогуур буюу 92.7 хувийн гүйцэтгэлтэй байгаа ч үүнийг шууд “төсвийн хэмнэлт” гэж үзэх боломжгүй. Хөрөнгө оруулалтын төсөл хугацаандаа хэрэгжээгүй бол санхүүжилт нь бага гарсан ч улсын хөрөнгө оруулалтын зорилго биелээгүй байж болно. Иймээс цаашид төсвийн гүйцэтгэлийг зөвхөн санхүүжилтийн гүйцэтгэлээр бус, хөрөнгө оруулалтын хэрэгжилтийн хугацаа болон биет гүйцэтгэл, үзүүлсэн үйлчилгээний чанар, хүрсэн үр дүнтэй нь холбон үнэлдэг байх нь чухал. МУНТ-ийн 2026 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн мэдээлэлд Төсвийн ерөнхийлөн захирагчдын хөтөлбөрийн үр дүнгийн үзүүлэлтүүдийн хэрэгжилтийн талаарх мэдээлэл тусгагдаагүй байсныг тэмдэглэе.
7. Эхний хагас жилийн гүйцэтгэлээс харахад төсвийн алдагдал төлөвлөсөн түвшнээс өндөр байгаа тул 2026 оны бүтэн жилийн төсвийн орлогын төлөвлөгөөг биелүүлэх боломж,

зарлага санхүүжилтийн төлөв, алдагдлын эрсдэлийг нэгтгэсэн байдлаар шинэчлэн, дахин үнэлэх шаардлага үүссэн байна.

8. Төсвийн алдагдал нь “орлого–зарлагын зөрүү” төдий бус, санхүүжилтийн бодлого, төсвийн тогтвортой байдлын гол асуудал болж байна. Төсвийн алдагдлын хэмжээ төдийгүй түүнийг ямар эх үүсвэрээр, ямар өртөг, хугацаа, валютын бүтэцтэйгээр санхүүжүүлж байгаа нь чухал юм. Ялангуяа орлого тасарсан үед шинээр өр үүсгэж, зээлээр нөхөх хандлагыг нэмэгдүүлэхгүй байхад УИХ анхаарал хандуулах хэрэгтэй.
9. Орон нутгийн төсвийн орлого 15.3 хувиар буюу 691.5 тэрбум төгрөгөөр тасарсан нь орон нутгийн төсвийн орлогын төлөвлөлт, өөрийн орлогын ба шилжүүлгийн бүтэц, орлогын баазын ялгаатай байдал, орлого төлөвлөлтийн үндэслэлийг дахин үнэлэх шаардлагатайг харуулж байна.

ГУРАВ. САНАЛ, ЗӨВЛӨМЖ

1. ***Төсвийн орлогын төлөвлөгөөг шинэчлэн үнэлэх.*** Татварын орлогыг ААНОАТ, онцгой албан татвар, импорттой холбоотой орлогын эхний хагас жилийн гүйцэтгэлд үндэслэн 2026 оны жилийн эцсийн орлогын бодит боломжийг дахин тооцож, шинэчлэх.
2. Төсвийн тэнцлийг сайжруулах бодлогын эхний чиглэл нь зарлагыг ижил хувиар хасаж, танахаас илүүтэй ***орлогын төлөвлөлтийн үндэслэлийг сайжруулах, орлогын эрсдэлийг урьдчилан тооцох.***
3. ***Татварын орлогын тасалдлын шалтгааныг татвар тус бүрээр тодорхойлох.*** Ялангуяа ААНОАТ-ын 865.7 тэрбум төгрөгийн тасалдалд салбарын бүтэц, ашигт ажиллагаа, татварын бааз, татварын өр, буцаан олголт болон төлөвлөлтийн аргачлалын нөлөөг тусад нь үнэлэх.
4. ***Жилийн сүүлийн хагасын төсвийн зарлагад эрэмбэ тогтоох.*** Орлогын тасалдал нэмэгдэх тохиолдолд зайлшгүй бөгөөд үр дүн, үр ашиг өндөртэй зардлыг хамгаалж, хойшлуулах боломжтой болон үр ашиг, үр дүн нь нотлогдоогүй зардлыг эрэмбэлж, орлого бүрдүүлэлттэй уялдуулан санхүүжүүлэх.
5. ***Төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн бүтцийг хянах.*** Шинээр авах дотоод, гадаад зээлийн хэмжээ, хүү, валютын бүтэц, хугацаа, өрийн үйлчилгээнээс учирч болох эрсдэлийг жилийн эцсийн төсөөлөлтэй уялдуулан үнэлэх. Төсвийн алдагдлыг нөхөх зорилгоор өндөр хүүтэй дотоод, гадаад бонд гаргахаас татгалзах.
6. ***Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөлтийг сайжруулах.*** Нийслэл, аймаг тус бүрээр орлогын тасалдлын шалтгааныг задлан шинжилж, орон нутгийн төсвийн орлогыг бодит баазад үндэслэн төлөвлөх.
7. ***Нийгмийн халамжийн зардлын үр нөлөөг үнэлэх.*** Хүүхдийн мөнгө болон бусад мөнгөн тэтгэмжийг зарцуулалтын хэмжээгээр бус, зорилтот бүлэгт хүрсэн байдал, ядууралд үзүүлсэн нөлөө, төсвийн зардлын өсөлттэй нь уялдуулан үнэлэх.
8. ***Төсвийн гүйцэтгэлийн мэдээллийг үр дүнтэй холбох.*** Жилийн эцсийн төсвийн гүйцэтгэлийн тайланд төсөвт хуваарилсан хөрөнгийн хэдэн хувь нь зарцуулагдсанаас гадна тухайн зардлаар ямар ажил үйлчилгээ үзүүлж, үр дүн бий болгосон талаар мэдээлэх.

9. **Төсвийн зарлагыг хумих.** Монгол Улсын төсвийн тогтвортой байдлыг хамгаалахын тулд өнөөгийн нөхцөлд төсвийн зарлагыг хумих, цаашид төсвийн тогтворжуулалтын санд нөөц хөрөнгө бүрдүүлэхэд анхаарах. Шатахуун болон үнийн өсөлтийн эсрэг авах арга хэмжээний хүрээнд төсвийн урсгал зардлыг танах зохицуулалтыг хийх, тухайлбал, цалин хөлснөөс бусад бараа, үйлчилгээний зардлыг бууруулах арга хэмжээ авах.
10. **Хуулиар тогтоосон төсвийн тусгай шаардлагуудыг хатуу мөрдөх,** төсвийн алдагдлыг Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл (ДХТХМ)-ээр тогтоосон хэмжээнд барих. Алдагдал өндөр хэвээр үргэлжилбэл олон улсын үнэлгээний байгууллагууд Монгол Улсын зээлжих зэрэглэлийг бууруулах эрсдэлтэй тул төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг чанд мөрдөх.
11. **Хагас жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлагналыг сайжруулах.** Энэ хүрээнд:
- Төсвийн зарцуулалтыг ангилал тус бүрээр нарийвчлан гаргаж, өмнөх оны мөн үетэй харьцуулах, жилийн төлөвлөгөөний биелэлттэй холбож харуулах
 - Тайланг график дүрслэл, диаграмм хэлбэрээр харуулах хэрэгсэл нэвтрүүлж, өгөгдлийг бодит цаг хугацаанд шинэчлэх системд шилжих
 - Олон нийтэд зориулсан хураангуй хувилбарыг цахим хуудсанд байршуулж, иргэдийн санал хүлээн авах, асуултад хариулах эргэх холбооны суваг бий болгох
 - Зөвхөн зарцуулсан мөнгөний дүнг биш, хэрэгжсэн ажлын бодит үр дүнг харуулж, төлөвлөсөн зорилтдоо хүрсэн эсэхийг тооцож тайлагнах
 - Алдаа дутагдлын шалтгааныг тодорхой бичиж, дараагийн хагас жилд засах төлөвлөгөө гаргаж байх
 - Макро эдийн засгийн суурь нөхцөлүүд өөрчлөгдсөн эсэх, төсвийн тусгай шаардлага жилийн эцэст мөрдөгдөх эсэх талаар эрсдэлийн үнэлгээ, төсвийн орлого, зарлагын чанарын үнэлгээ, жилийн үлдсэн хугацаанд хэрэгжүүлэх шаардлагатай төсвийн бодлогын саналуудыг тусгах шаардлагатай гэж үзэж байна.

Хавсралт 1. Улсын төсвийн 2026 оны эхний хагас жилийн гүйцэтгэл, тэрбум төгрөг

Үзүүлэлт	2025 оны эхний хагас жилийн гүйцэтгэл	2026 оны			Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулсан зөрүү	төлөвлөгөө гүйцэтгэлийн зөрүү
		жилийн төсөв	эхний хагас жилийн төлөвлөгөө	эхний хагас жилийн гүйцэтгэл		
Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн	7,875.9	20,164.5	9,757.3	8,524.3	648.4	(1,233.0)
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	9,311.2	22,885.2	12,254.2	11,318.9	2,007.7	(935.3)
Тэнцвэржүүлсэн нийт тэнцэл	(1,435.3)	(2,720.7)	(2,497.0)	(2,794.6)	(1,359.3)	(297.7)

Хавсралт 2. Орон нутгийн төсвийн 2026 оны эхний хагас жилийн гүйцэтгэл, тэрбум төгрөгөөр

Үзүүлэлт	2025 оны эхний хагас жилийн гүйцэтгэл	2026 оны			Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулсан зөрүү	төлөвлөгөө гүйцэт- гэлийн зөрүү
		жилийн төсөв	эхний хагас жилийн төлөвлөгөө	эхний хагас жилийн гүйцэтгэл		
Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн	3,650.1	7,330.1	4,508.8	3,817.3	167.2	(691.5)
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	3,196.5	7,330.1	4,503.4	3,709.7	513.2	(793.7)
Тэнцвэржүүлсэн нийт тэнцэл	453.6	(0.0)	5.4	107.6	(346.0)	102.2

Хавсралт 3. Нийгмийн даатгалын сангийн 2026 оны эхний хагас жилийн гүйцэтгэл, тэрбум төгрөгөөр

Үзүүлэлт	2025 оны эхний хагас жилийн гүйцэтгэл	2026 оны			Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулсан зөрүү	төлөвлөгөө гүйцэтгэлийн зөрүү
		жилийн төсөв	эхний хагас жилийн төлөвлөгөө	эхний хагас жилийн гүйцэтгэл		
Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн	3,220.5	7,824.7	3,732.9	3,814.6	594.1	81.7
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	2,902.9	6,517.5	3,328.0	3,335.7	432.8	7.8
Тэнцвэржүүлсэн нийт тэнцэл	317.5	1,307.2	404.9	478.9	161.3	73.9

Хавсралт 4. Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны эхний хагас жилийн гүйцэтгэл, тэрбум төгрөгөөр

Үзүүлэлт	2025 оны эхний хагас жилийн гүйцэтгэл	2026 оны			Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулсан зөрүү	төлөвлөгөө гүйцэтгэлийн зөрүү
		жилийн төсөв	эхний хагас жилийн төлөвлөгөө	эхний хагас жилийн гүйцэтгэл		
Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн	1,161.5	2,746.7	1,305.1	1,282.2	120.7	(22.9)
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	1,255.2	2,383.3	1,236.1	1,217.6	(37.6)	(18.4)
Тэнцвэржүүлсэн нийт тэнцэл	(93.7)	363.5	69.0	64.6	158.3	(4.5)

Хавсралт 5. Нэгдсэн төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр, тэрбум төгрөгөөр

АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	Өмнөх оны мөн үед	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	583.0	2,316.8	1,154.1	49.8	(1,162.7)
Засгийн газрын бонд	460.0	(26.0)	779.0	(3,001.4)	805.0
Засгийн газрын зээл	(285.1)	(289.8)	210.0	(72.5)	499.8
Өмч хувьчлал	0.1	16.5	0.5	2.8	(16.0)
Нийт дүн	758.0	2,017.6	2,143.6	106.2	126.0

Хавсралт 6. Нэгдсэн төсвийн орлогын 2026 оны эхний хагас жилийн гүйцэтгэл, тэрбум төгрөг, шатлалаар

Ангилал	Улсын төсөв		Орон нутгийн төсөв		Нийгмийн даатгалын сан		Эрүүл мэндийн даатгалын сан	
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	9,968.0	9,005.0	4,508.8	3,817.3	3,732.9	3,814.6	1,305.1	1,282.2
ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН	210.7	480.7	-	-	-	-	-	-
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	9,757.3	8,524.3	4,508.8	3,817.3	3,732.9	3,814.6	1,305.1	1,282.2
Татварын орлого	8,248.3	7,321.7	3,718.9	3,121.7	2,842.7	2,924.4	1,305.1	1,282.2
Орлогын албан татвар	1,950.5	1,565.4	3,087.0	2,446.2	-	-	-	-
Нийгмийн даатгалын орлого	-	-	-	-	2,842.7	2,924.4	1,305.1	1,282.2
Хөрөнгийн албан татвар	-	-	372.7	380.7	-	-	-	-
Нэмэгдсэн өртгийн албан татвар	3,430.0	3,219.8	-	-	-	-	-	-
Онцгой албан татвар	625.9	438.3	-	-	-	-	-	-
Тусгай зориулалтын орлого	14.7	14.8	-	-	-	-	-	-
Гадаад үйл ажиллагааны орлого	1,099.0	962.7	-	-	-	-	-	-
Бусад татвар, төлбөр, хураамж	1,128.2	1,120.6	259.2	294.9	-	-	-	-
Татварын бус орлого	1,509.0	1,202.6	789.9	695.6	890.2	890.2	-	-
Нийтлэг татварын бус орлого	547.0	598.9	481.3	421.0	-	-	-	-
Хөрөнгийн орлого	-	-	2.3	1.4	-	-	-	-
Тусламжийн орлого	193.0	181.9	6.2	1.7	890.2	890.2	-	-
Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	769.0	421.8	300.0	271.5	-	-	-	-

Хавсралт 7. Нэгдсэн төсвийн зарлагын 2026 оны эхний хагас жилийн гүйцэтгэл, тэрбум төгрөг, төсвийн шатлалаар

Ангилал	Улсын төсөв		Орон нутгийн төсөв		Нийгмийн даатгалын сан		Эрүүл мэндийн даатгалын сан	
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	12,254.2	11,318.9	4,503.4	3,709.7	3,328.0	3,335.7	1,236.1	1,217.6
НИЙТ ЗАРЛАГА	12,334.0	11,290.9	4,398.2	3,629.6	3,361.6	3,342.2	1,236.1	1,218.6
УРСГАЛ ЗАРДАЛ	10,740.0	9,806.5	2,930.7	2,339.5	3,361.6	3,342.2	1,236.1	1,218.6
Бараа, ажил үйлчилгээний зардал	5,657.1	5,209.6	1,637.0	1,317.6	0.7	0.3	7.1	7.0
Зээлийн үйлчилгээний төлбөр	650.4	530.1	273.0	262.3	0.0	0.0	0.0	0.0
Татаас	1,273.3	1,194.9	258.5	249.5	0.0	0.0	0.0	0.0
Урсгал шилжүүлэг	3,159.1	2,871.9	762.2	510.0	3,360.8	3,341.9	1,229.0	1,211.6
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,594.1	1,484.5	1,467.4	1,290.1	0.0	0.0	0.0	0.0
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	-79.8	28.0	105.2	80.2	-33.6	-6.5	0.0	-1.0
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-2,497.0	-2,794.6	5.4	107.6	404.9	478.9	69.0	64.6

Хавсралт 8. 2026 оны жилийн эцсийн 3 хувилбарын тооцоо

Энэхүү хувилбарын тооцоо нь жилийн төсөв, эхний хагас жилийн төлөв болон гүйцэтгэлийг ашиглан хийсэн аналитик тооцоо бөгөөд албан ёсны шинэчилсэн төсөөлөл биш. Жилийн төсвөөс эхний хагас жилийн төлөвлөгөөг хасаж тооцсон.

Хувилбар	Жилийн орлого	Жилийн зарлага + цэвэр зээл	Жилийн тэнцэл	Тайлбар
Өөдрөг	30,489.6	30,921.0	-431.4	
Суурь	30,489.6	31,665.6	-1,176.0	
Эрсдэлтэй	28,903.6	32,410.2	-3,506.6	

Өөдрөг хувилбар: II хагасын орлого жилийн төлөвлөгөөг 100% биелүүлнэ; зарлага үлдсэн төлөвлөгөөний 95%-д баригдана.

Суурь хувилбар: II хагасын орлого, зарлага жилийн төлөвлөгөөтэй тэнцүү гүйцэтгэгдэнэ.

Эрсдэлтэй хувилбар: II хагасын орлого үлдсэн жилийн төлөвлөгөөний 90%; зарлага 105% байна.

Тайлбар: “Суурь” хувилбар нь жилийн төлөвлөгөөг бүрэн хэрэгжүүлсэн ч эхний хагасын орлогын тасалдал бүхэлдээ нөхөгдөхгүй гэсэн тооцоонд үндэслэж, жилийн тэнцлийг ойролцоогоор -1.18 их наяд төгрөгт хүргэнэ. “Эрсдэлтэй” хувилбарт орлогын сэргэлт сул, зарлага үлдсэн төлөвлөгөөнөөс 5%-иар өндөр гэж үзсэн тул алдагдал ойролцоогоор -3.51 их наяд төгрөгт хүрэхээр байна. “Өөдрөг” хувилбар нь орлогын жилийн төлөвлөгөө бүрэн биелж, зарлага 5%-иар хязгаарлагдсан нөхцөлд алдагдал -0.43 их наяд төгрөг орчим байна.

Иймд жилийн эцсийн төсвийн алдагдал нь ойролцоогоор 0.43–3.51 их наяд төгрөгийн хооронд хэлбэлзэх эрсдэлтэй гэж энэхүү механик хувилбарын тооцоо харуулж байна. Гэхдээ энэ хүрээ нь макро эдийн засгийн шинэ таамаглал, улирлын шинж, уул уурхайн орлого, татвар төлөлтийн хуваарь, өрийн санхүүжилтийн бодит нөхцөлийг тусгаагүй тул Сангийн яамны шинэчилсэн төсөөллөөр дахин тооцох шаардлагатай.